



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/14/-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор: Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: sunjidmaae@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Л.НАСАНБУЯН ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 176
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07020491

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/	3
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/	4
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/	8
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	11
3.5.1 Орлогын данс	11
3.5.2 Зардлын данс	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлсэн сан

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,058,421.8	1,214,425.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	111,553.1	145,296.0
33	АВЛАГА	300,742.2	359,178.8
34	УРЬДЧИЛГАА	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	594,726.5	662,450.3
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	19,900.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	51,400.0	27,600.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,038,904.2	5,765,513.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,038,904.2	5,765,513.0
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	5,949,682.7	5,681,237.5
39300	Биет бус хөрөнгө	89,221.5	84,275.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,097,326.0	6,979,938.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,563.8	5,463.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,563.8	5,463.8
41300	Өглөг	9,563.8	5,463.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,087,762.3	6,974,474.4
51	Засгийн газрын хувь оролцоо	7,087,762.3	6,974,474.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,902,466.2	1,902,466.2
51200	Хуримтлагдсан үр дүн	4,619,172.0	4,667,136.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	566,124.0	404,871.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,097,326.0	6,979,938.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,905,220.2	3,068,648.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	84,485.8	80,210.8
110	Орлогын албан татвар	73,903.5	61,860.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	73,903.5	61,860.4
113	Хөрөнгийн албан татвар	3,510.0	3,272.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	7,072.3	15,078.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,907,131.4	383,679.8
120	Нийтлэг татварын бус орлого	1,907,131.4	383,679.8

Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,913,603.0	2,604,758.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,133,432.8	2,762,495.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,133,432.8	2,762,495.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,322,198.3	2,671,536.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,423,363.2	1,542,932.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,826.7	202,222.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,600.7	143,519.8
2104	Хангамж, бараа материалын зардал	93,811.8	103,032.9
2105	Нормативт зардал	71,434.5	268,467.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,613.0	3,666.0
2107	Томилолт, зочны зардал	6,433.0	6,499.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,953.9	30,079.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	343,161.6	371,116.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	811,234.5	90,959.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,771,787.4	306,152.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	56,070.1	419,440.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,715,717.3	-113,287.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,093,907.7	2,784,327.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	84,485.8	80,210.8
110	Орлогын албан татвар	73,903.5	61,860.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	73,903.5	61,860.4
113	Хөрөнгийн албан татвар	3,510.0	3,272.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	7,072.3	15,078.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,117.5	7,625.4
1181	Газрын төлбөр	904.8	1,537.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	50.0	5,915.5
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,818.9	198,220.3
120	Нийтлэг татварын бус орлого	95,818.9	198,220.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,913,603.0	2,505,896.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,841,073.7	2,332,999.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,841,073.7	2,332,999.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,029,839.2	2,242,039.4

Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,423,253.1	1,542,888.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	184,065.4	202,222.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,300.4	142,875.5
2104	Хангамж, бараа материалын зардал	100,706.0	92,545.5
2105	Нормативт зардал	69,056.6	161,515.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,343.2	5,690.2
2107	Томилолт, зочны зардал	6,538.0	6,499.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,617.3	36,526.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,959.1	51,276.1
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	811,234.5	90,959.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	252,834.0	451,328.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	112,126.0	276,085.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	112,126.0	276,085.0
2200	Дотоод эх үүсвэрээр	112,126.0	276,085.0
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-112,126.0	-276,085.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-53,900.0	-141,500.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	53,900.0	141,500.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	86,808.0	33,743.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,745.0	111,553.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	111,553.1	145,296.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төсөвт байгууллага	Төрийн сан	Нэгтгэсэн нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,415,474.7	19,281.6	5,434,756.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-57,675.0	0.0	-57,675.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,357,799.7	19,281.6	5,377,081.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-5,036.4	0.0	-5,036.4
9	Тайлант үеийн үр дүн	1,677,452.9	38,264.4	1,715,717.3
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,030,216.3	57,546.0	7,087,762.3
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,030,216.3	57,546.0	7,087,762.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	394.4	0.0	394.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,030,610.7	57,546.0	7,088,156.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-394.4	0.0	-394.4
19	Тайлант үеийн үр дүн	-113,106.1	-181.8	-113,287.9

20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,917,110.2	57,364.2	6,974,474.4
----	---------------------------------------	-------------	----------	-------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,691,548.00	2,571,977.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,302,044.10	2,197,342.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,264,136.40	2,161,155.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,590,998.20	1,516,467.27
210101	Үндсэн цалин	1,282,210.20	1,247,570.61
210102	Нэмэгдэл	65,000.00	60,044.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,500.00	3,857.00
210104	Урамшуулал	84,909.80	70,081.26
210105	Гэрээт ажлын хөлс	154,378.20	134,913.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	217,494.70	198,792.35
210201	Тэтгэврийн даатгал	154,699.20	140,023.06
210202	Тэтгэмжийн даатгал	15,665.20	15,297.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,596.80	12,046.84
210204	Ажилгүйдлийн даатгал	3,131.60	2,848.23
210205	Эрүүл мэндийн даатгал	31,401.90	28,576.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,452.00	142,642.15
210301	Гэрэл, цахилгаан	20,300.00	18,243.30
210302	Түлш, халаалт	116,752.00	117,368.85
210303	Цэвэр, бохир ус	7,400.00	7,030.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	82,281.60	80,456.95
210401	Бичиг хэрэг	9,777.40	9,623.05
210402	Тээвэр, шатахуун	57,088.80	57,058.19
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,980.00	4,574.99
210404	Ном, хэвлэл	587.00	481.34
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	945.00	848.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,903.40	7,870.80
2105	Нормативт зардал	109,394.10	108,271.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,722.70	24,722.05
210502	Хоол, хүнс	66,511.40	66,489.46
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,160.00	17,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,495.70	46,490.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,095.70	17,095.70
210602	Тавилга	25,000.00	25,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,200.00	1,200.00
210604	Урсгал засвар	3,200.00	3,194.50
2107	Томилолт, зочны зардал	9,678.00	6,172.50
210702	Дотоод албан томилолт	9,678.00	6,172.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,959.70	10,586.38

Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,329.70	6,995.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,452.00	648.00
210803	Даатгалын үйлчилгээ	254.00	54.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	630.00	375.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121.00	88.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,640.00	780.00
210807	Газрын төлбөр	200.00	199.78
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	833.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500.00	1,446.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,382.40	51,276.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,054.30	43,003.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,328.10	8,272.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,907.70	36,187.20
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,907.70	36,187.20
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,727.70	25,602.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,180.00	10,585.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	246,083.90	233,135.04
223001	Бусад хөрөнгө	246,083.90	233,135.04
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	143,420.00	141,500.00
230001	Эргэж төлөгдөх зээл	143,420.00	141,500.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,691,548.00	2,611,278.60
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,610,593.30	1,583,898.53
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,610,593.30	1,583,898.53
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	863,591.60	840,268.14
320001	Орон нутгийн төсвөөс	666,507.70	643,184.24
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	197,083.90	197,083.90
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,463.10	2,592.55
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,463.10	2,592.55
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	192,900.00	184,519.37
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	95,000.00	165,987.31
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,900.00	18,532.07
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	34,000.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	51,843.35
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	84,818.13

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Т3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		151,911.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ		149,761.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		121,684.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		26,421.61
210101	Үндсэн цалин		2,973.99
210104	Урамшуулал		23,447.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,429.64
210201	Тэтгэврийн даатгал		2,349.58
210202	Тэтгэмжийн даатгал		270.02
210203	ҮОМШӨ-ний даатгал		216.01
210204	Ажилгүйдлийн даатгал		54.00
210205	Эрүүл мэндийн даатгал		540.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		233.32
210301	Гэрэл, цахилгаан		233.32
2104	Хангамж, бараа материалын зардал		12,088.54
210401	Бичиг хэрэг		3,336.16
210402	Тээвэр, шатахуун		6,429.38
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		134.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,189.00
2105	Нормативт зардал		53,243.88
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		47,272.89
210502	Хоол, хүнс		5,970.99
2107	Томилолт, зочны зардал		327.06
210702	Дотоод албан томилолт		327.06
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		25,940.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		25,940.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		28,077.78
2132	Бусад урсгал шилжүүлэг		23,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		23,800.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		4,277.78
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		2,800.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,477.78
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		2,150.00
2200	Дотоод эх үүсвэрээр		2,150.00

Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		2,150.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		151,911.83
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		151,911.83
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		58,504.08
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,579.75
131106	Хаагдсан данс		0.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		90,828.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цогт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 29 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх ойрын бодлогыг зөв зохистой тодорхойлох иргэдийн эрх ашгийг хамгаалан, сайн сайхан амьдрах орчин бүрдүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангах чиг үүрэг бүхий аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа нэгж юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов. Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт зардлын 2,000.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 40.0 сая төгрөгөөр, төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 32.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт зардлаас 2,762.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 55.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 44.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2 хувиар буюу 218.7 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 145.3 сая төгрөг болж өссөн ба энэ өсөлтөд голлон сум хөгжүүлэх сан болон эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэн нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 359.2 сая төгрөг болж өссөн нь сумын Эрүүл мэндийн төвийн төлбөртэй үйлчилгээний авлага, болон сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэлтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 662.5 сая төгрөг болж 67.7 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 408.9 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 193.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 494.1 сая төгрөгийн материалыг зарцуулж, 20.7 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,395.3 сая төгрөг болж 218.7 сая төгрөгөөр буурсан. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 42.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 263.2 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр, 82.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 442.5 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 5.5 сая төгрөг болж 4.1 сая төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,088.2 сая төгрөг болж 113.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 6,974.5 сая төгрөг болсон байна.

3.5.1 Орлогын данс

Тайлант онд 80.2 сая төгрөгийн татварын орлого, 383.7 сая төгрөгийн татварын бус орлого, 2,604.7 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 3,068.6 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.2 Зардлын данс

Тайлант онд 2,762.5 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 306.1 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Цогт сумын ИТХ-ын 2020 оны 12 дүгээр сарын “Сумын 2020 оны төсөв тодотгон батлах тухай” 08 дугаар тогтоолд зааснаар Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 61.8 сая төгрөгийн татварын 12.4 сая төгрөгийн татварын бус нийт 72.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 92.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 186 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс давуулан биелүүлсэн байна.

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн байгууллагуудын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Харин тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хувьд дээд шатны төсөв захирагчдаа тус тус хүргүүлжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийг 2,691.5 сая төгрөгөөр баталсан байна

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,691.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас зардлын 1,610.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 666.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 197.0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 24.4 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 112.9 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн авсан.

Төсвийг бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулаагүй. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 115.9 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 58.5 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2.6 сая төгрөгийг, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 90.8 сая төгрөгийг тус тус тайлагнасан зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цогт сумын ИТХ нь тайлант хугацаанд Шилэн дансанд байршуулах мэдээллээс 1 мэдээллийн 12.4 сая төгрөгийг мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Цогт сумын Соёлын төв нь тайлант хугацаанд Шилэн дансанд байршуулах мэдээллээс 3 мэдээллийн 22.9 сая төгрөгийг мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 168 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Сум хөгжүүлэх сангийн төлөгдөөгүй актын үлдэгдэл 14.1 сая төгрөг байна. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын байдалд 2015 онд хийсэн нийцлийн аудитаар өгөгдсөн 6.4 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна. Төсөвт захирагч нарт мэдэгдэх хуудас хүргүүлсэн хэдий ч тодорхой үр дүнтэй арга хэмжээ аваагүй боловч удирдлага солигдсон тул мэдэгдэл хүргүүлж байна.

Харьяа нэгж байгууллагын тухайд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчдад нэгтгэгдэг нэгж байгууллагуудын шийдвэрийн хэрэгжилтийн талаар аудитын тайланд дэлгэрэнгүй тусгасан болно. Харьяа нэгж байгууллагад өмнөх оны шийдвэрийн үлдэгдэл байхгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитын шийдвэрийг хэрэгжилт, орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг үзэх нь зүйтэй

4. Аудитын илрүүлэлт

Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллага, 1 санд дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 2 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 2, дүгнэлт, хязгаарлалттай 3 санал дүгнэлт авсан байна.

Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад 1,229.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 240.6 сая төгрөгийн алдааг залруулж, 29.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 949.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 10.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар 12.3 сая төгрөгийн зөрчил илэрч 4.2 сая төгрөгийн залруулга, 8.1 сая төгрөгийн албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлээ.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийгдсэн залруулга:

Цогт сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй болно.

Түүвэрт хамрагдсан байгууллагын тухайд:

Соёлын төвийн ө баримт 4.2 сая төгрөгийг нөхөн шивүүлж залрууллаа.

4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт

Цогт сумын нэгтгэсэн тайлан болон түүвэрт хамрагдсан байгууллагын аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно

4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно

Түүвэрт хамрагдсан байгууллагын хувьд:

Цогт сумын ИТХ

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10- аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны /төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын .."үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн горим зөрчиж ИТХ-тэргүүлэгчдийн хоол болон бичиг хэргийн зардал 2.4 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т/төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/ гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ. Ө баримтгүй 5.7 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ

Цогт сумын Соёлын төв

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10- аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны /төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын /үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ

4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Түүвэрт хамрагдсан байгууллага хувьд

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Цогт сумын ИТХ

Илрүүлэлт: Шилэн дансанд байршуулах мэдээллээс 1 мэдээллийн 12.4 сая төгрөгийг мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Цогт сумын Соёлын төв

Илрүүлэлт: Шилэн дансанд байршуулах мэдээллээс 3 мэдээллийн 22.9 сая төгрөгийг мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Цогт сумын Засаг дарга

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цогт сумын Цэцэрлэг, Соёлын төв, ЗДТГ, Эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээг дүгнэж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах,” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

		/сая төгрөгөөр/									
д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
	Цогт сумын Төвлөрүүлэн захирагч	1						1			
Түүвэрт хамрагдсан байгууллага											
	Соёлын төв	1	4.3	1	4.3						
	ИТХ	3	8.0					3	8.0		
	Дүн	5	12.3	1	4.3			5	8.0		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
	Дүн										
	Соёлын төв	1								1	

Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ИТХ	1							1	
Дүн	2							2	
Нийт дүн	7	12.3	1	4.3			5	2	